



СОЁЛЫН ЯАМ



**“МОНГОЛ УЛСЫН БАРИМТАТ ӨВИЙН  
БҮРТГЭЛ”-Д НЭР ДЭВШҮҮЛЭХ ДУРСГАЛЫГ  
БҮРТГЭХ АРГАЧЛАЛ**

## ГАРЧИГ

|   |       |
|---|-------|
| Өмнөх үг .....  | 2-5   |
| Соёлын өвийг хамгаалах тухай<br><i>/шинэчилсэн найруулгын хэсгээс/</i> .....  | 6-22  |
| Баримтат өвийн тухай ойлголт .....  | 23-25 |
| Баримтат өвийн төрөл зүйл .....   | 26-30 |
| Баримтат өвийн агуулгын ангилал .....   | 31-35 |
| “Монгол Улсын баримтат өвийн бүртгэл”-д<br>нэр дэвшүүлэх дурсгалыг бүртгэх аргачлал,<br>шалгуур үзүүлэлт .....                | 36-49 |
| “Монгол Улсын баримтат өвийн бүртгэл”-д нэр<br>дэвшүүлэх дурсгалыг таньж тогтоох шалгуур<br>үзүүлэлтийн ажлын даалгавар ..... | 50-55 |
| Баримтат өвийн жагсаалт .....   | 56-59 |
| Монгол улсаас Ази-номхон далайн бүс нутгийн<br>болон дэлхийн өвд бүртгүүлсэн өвийн<br>жагсаалт .....                          | 60-70 |
| Баримтат өвийн хүртээмж .....   | 71-74 |
| <b>Хавсралт</b> .....   | 75-81 |
| <b>Товчилсон үг</b> .....   | 82    |
| <b>Ашигласан материал</b> .....   | 83    |

## ӨМНӨХ ҮГ

Монгол Улс ЮНЕСКО-д элсэн орсон цагаас хойш явуулж буй үйл ажиллагаанд нь идэвхтэй оролцож, зарим конвенцид нэгдэн орж боловсрол, байгалийн болон нийгмийн шинжлэх ухаан, соёл, мэдээлэл харилцаа, холбооны салбарт эрх зүй, ёс суртахууны нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээг тогтооход өөрийн хувь нэмрээ оруулж байна.

Монгол Улсын нутаг дэвсгэрт эрт үеэс янз бүрийн нүүдэлчин ард түмэн нутаглан аж төрж, улс гүрэн байгуулж, түүх соёлоо хөгжүүлж иржээ. Үүнийг гэрчлэх, нотлох баримт эх сурвалж нь монгол бичиг үсгүүдээр төдийгүй бусад үндэстний бичиг үсгээр тэмдэглэн үлдээсэн бичиг соёлын өв арвин байдаг билээ. Тиймээс бичиг үсгээр тэмдэглэн үлдээсэн ном бичгийн зүйл, эх сурвалжийг өнөөгийн ойлголтоор Баримтат өв хэмээх төрөлд хамааруулан энэ төрлийн өвийг олж илрүүлэх, судлах, улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг Монгол Улсын Соёлын яам, Соёлын өвийн үндэсний төвөөс эрчимтэй зохион байгуулж байна. Энэ ажлын хүрээнд “Монгол Улсын баримтат өвийн

бүртгэл”-д нэр дэвшүүлэх өвийг бүртгэх, аргачлал, зөвлөмжийг эрхлэн гаргав. Энэхүү зөвлөмжийн гол зорилго нь УНБМСанд соёлын өвийг эзэмшигч, өмчлөгч байгууллага, иргэдийн гар дээр хадгалагдаж байгаа баримтат өвийн мэдээллийг төвлөрүүлэх, бүртгэх явдал юм. Энэ удаа бид бичиг соёлын өв дурсгалуудаас мэдээллийн ач холбогдол, бүтээсэн ур хийц нь ховор нандин, хосгүй гайхамшигтай, үндэсний хэмжээнд бахархалт өв дурсгал болж чадахуйц Баримтат өвийн бүртгэл мэдээллийн сан бүрдүүлж, улмаар Ази-Номхон далайн бүс нутгийн болон дэлхийн өвийн жагсаалтад бүртгүүлэх боломжтой болох юм. Иймээс энэхүү гарын авлагад Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн холбогдох хэсэг, “Баримтат өв” гэж юуг ойлгох, ямар төрөл зүйл байх, хэрхэн ангилж болох, баримтат өвийг хэрхэн олж таних, хэрхэн яаж, ямар загвар шалгуураар бүртгэл хийх, бүтэц зохион байгуулалт, ач холбогдол хүртээмжийн талаар анхан шатны ойлголт, мэдээлэл, арга зүй болгож байгаа юм. Энэхүү үйл ажиллагааг хэрэгжүүлэн биелүүлэхэд нийт ард иргэд, соёлын ажилтнууд, монголын түүх соёлыг сонирхон судлагчид, цуглуулагчдын оруулах хувь нэмэр асар их тул баримтат өвийг бүртгэхэд нэгдсэн нэг ойлголттой байж, улсын хэмжээнд ижил нэг

төрлийн загвар маягт, шалгуур аргачлал хэрэгтэйг чухалчлан үзлээ.

“Монгол Улсын баримтат өвийн бүртгэл”-д нэр дэвшүүлэх өвийг бүртгэх, аргачлал, зөвлөмжийг соёлын өвийг бүртгэх хууль, эрх зүйн акт, удирдлагын бичиг баримтууд, УНБМСангийн Музейн үзмэр, эд өлгийн зүйлийн ерөнхий бүртгэлийн программ (Register) Түүх, соёлын хөдлөх дурсгалын бүртгэлийн “RCH 2.0” программтай тус тус уялдуулан боловсруулсан болно. Энэхүү зөвлөмж Монгол Улсын түүхэнд холбогдох баримтат өвийн бүртгэл судалгааны түвшнийг тогтоох, мөн шинээр илрүүлэн олж түүхийн хуудсыг баяжуулан нөхөх ажлыг нэгдсэн арга зүйгээр хангахад чухал ач холбогдолтой юм. Ийм учраас дараах зорилтыг шийдвэрлэх боломж нөхцөл бүрдэнэ хэмээн үзэж байна.

- Үндэсний баримтат өвийн жагсаалт гаргах, тэдгээрийг шинжлэх ухааны үндэслэлтэй судлах, сурвалжлан олж цуглуулах иргэн, аж ахуйн нэгжийн оролцоог нэмэгдүүлж идэвх санаачлагыг өрнүүлэх боломж нээгдэнэ.
- ЮНЕСКО-гийн “Дэлхийн дурсамж” хөтөлбөрийн баримтат өвийн жагсаалтад Монгол Улсын бичгийн өв дурсгалуудыг

оруулах олон нийтэд сурталчлах боломж нээгдэнэ.

- Улсын бүртгэл мэдээллийн санд бүртгэснээр хадгалалт хамгаалалт сайжирч хойч үедээ өвлүүлэн үлдээх боломж нээгдэнэ.
- Үндэсний хэмжээнд өв соёлоороо бахархах үзэл төлөвшүүлэхэд тус нэмэр болно хэмээн үзэж байгаа юм.



2014 оны 5 дугаар  
сарын 15-ны өдөр

Улаанбаатар хот

**СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ  
/ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ХЭСГЭЭС/**

**ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ  
СОЁЛЫН ӨВИЙН БҮРТГЭЛ**

**20 дугаар зүйл. Соёлын өвийн бүртгэл,  
мэдээллийн сангийн тогтолцоо**

20.1. Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан нь дараах тогтолцоотой байна:

20.1.1. байгууллагын бүртгэл, мэдээллийн сан;

20.1.2. сум, дүүргийн бүртгэл, мэдээллийн сан;

20.1.3. аймаг, нийслэлийн бүртгэл, мэдээллийн сан;

20.1.4. улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан.

20.2. Сум, дүүргийн бүртгэл, мэдээллийн санг соёлын төвд; аймгийн бүртгэл, мэдээллийн санг орон нутгийн музейд; нийслэлийн бүртгэл,

мэдээллийн санг нийслэлийн Засаг даргын дэргэдэх соёлын асуудал хариуцсан нэгжид; улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санг Соёлын өвийн үндэсний төвд тус тус бүрдүүлж, хадгална.

20.3.Соёлын өвийн үндэсний төв нь соёлын өвийг бүртгэх, судлах, хадгалах, сэргээн засварлах, авран хамгаалах, сурталчлах чиг үүрэг бүхий соёл, эрдэм шинжилгээний байгууллага байна.

*/Энэ хэсгийг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./*

20.4.Төрийн болон орон нутгийн музей нь тухайн нутаг дэвсгэрт орших соёлын өвийг бүртгэх, цуглуулах, хадгалж хамгаалах, судлах, сурталчлах чиг үүрэг бүхий соёл, эрдэм шинжилгээний байгууллага байна.

*/Энэ хэсэгт 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./*

20.5.Сум, дүүргийн соёлын төв нь тухайн нутаг дэвсгэрт орших соёлын өвийг бүртгэн баримтжуулах, хамгаалах үүргийг гүйцэтгэнэ.

20.6.Дараах аж ахуйн нэгж, байгууллага бүртгэл, мэдээллийн санг заавал бүрдүүлнэ:

20.6.1.Монгол банк;

20.6.2.дурсгалт газрын хамгаалалтын захиргаа;

20.6.3.музей, галерей, номын сан, сүм хийд;

20.6.4.эрдэм шинжилгээний байгууллага, судалгааны лаборатори.



20.6.5.үндэсний төв архив.

/Энэ заалтыг 2020 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн хуулиар нэмсэн./

20.7.Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд иргэн, хуулийн этгээд өөрийн өмчилж, эзэмшиж байгаа соёлын өвийг бүртгүүлж болно.

20.8.Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санг цаасан болон цахим хэлбэрээр бүрдүүлэх бөгөөд түүнд агуулагдах мэдээлэл үнэн зөв, бүрэн гүйцэд, зөрүүгүй байна.

20.9.Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан нь төрийн өмчид байна.

20.10.Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн байрлал, нууцлал, хадгалалт, хамгаалалтын аюулгүй байдлыг тухайн санг бүрдүүлсэн байгууллага хариуцна.

## **21 дүгээр зүйл. Соёлын өвийн бүртгэлийн бүрдэл**

21.1.Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан нь соёлын өвийг эвдэрч гэмтсэн, устсан, мартагдсан тохиолдолд тэдгээрийг сэргээхэд шаардагдах бүрэн мэдээллийг агуулсан байвал зохино.

21.2.Соёлын өвийн бүртгэл нь дараах дагалдах хэрэглэгдэхүүнээс бүрдэнэ:

21.2.1.соёлын өвийн тодорхойлолт;

21.2.2.судалгаа, шинжилгээний ажлын тайлан;

- 21.2.3.сэргээн засварласан ажлын тайлан;
  - 21.2.4.үзлэг, тооллого хийхэд хөтөлсөн баримт;
  - 21.2.5.дотоод, гадаадад гаргасан үзэсгэлэнтэй холбоотой баримт;
  - 21.2.6.гэрэл зураг, түүнийг агуулсан хальс, зээрэнцэг;
  - 21.2.7.дуу, дүрс агуулсан бүх төрлийн бичлэг;
  - 21.2.8.хэв, хуулбар, дардас;
  - 21.2.9.соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн талаарх мэдээлэл;
  - 21.2.10.сэргээн засварлах ажлын хэмжилт, судалгаа, зураг төсөл;
  - 21.2.11.бүртгэлд холбогдох бусад хэрэглэгдэхүүн.
- 21.3.Соёлын өвийн бүртгэл, түүнд дагалдах хэрэглэгдэхүүн нь лавлагаа, мэдээллийн хувьд нэгдмэл цогц байх нөхцөлийг бүрдүүлнэ.
- 21.4.Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн бүртгэлийг хуульд зааснаас бусад үндэслэлээр дамжуулах, ашиглуулах, хувилах, үрэгдүүлэх болон стандартын бус орчинд хадгалахыг хориглоно.
- 21.5.Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийг архивын байгууллагад хадгалуулна.

## **22 дугаар зүйл.Соёлын өвийг бүртгэх**

22.1.Соёлын өвийг бүртгэл, мэдээллийн санд бүртгэх, мэдээллийг ашиглах журмыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн

батална. Эрдэнэсийн санд хадгалагдаж байгаа түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг бүртгэх журмыг Монгол банкны Ерөнхийлөгч, соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

/Энэ хэсэгт 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./

22.2.Нийтийн өмчийн соёлын биет өвийн талаарх мэдээллийг бүртгэл, мэдээллийн санд заавал бүртгэнэ.

22.3.Энэ хуулийн 22.2-т зааснаас бусад соёлын биет өвийг өмчлөгч, эзэмшигчийн хүсэлтийг үндэслэн зохих шатны бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлж болно. Бүртгүүлсэн мэдээллийн нууцлал, хадгалалтын нөхцөлийг гэрээгээр зохицуулна.

22.5.Соёлын өв устсан, үрэгдсэн тохиолдолд Мэргэжлийн зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр төрийн болон орон нутгийн өмчөөс хасна.

22.6.Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангаас мэдээлэл хасахыг хориглоно.

### **23 дугаар зүйл. Соёлын өвийг бүртгэх хугацаа**

23.1.Соёлын өвийг нээж, илрүүлсэн байгууллага, иргэн тухайн нутаг дэвсгэрийн бүртгэл,

мэдээллийн санд 15 хоногийн дотор мэдэгдэж, анхан шатны бүртгэл хийлгэнэ.

23.2.Байгууллагын бүртгэл, мэдээллийн сан нь жилд дөрвөн удаа сум, дүүргийн, сум, дүүргийн бүртгэл, мэдээллийн сан нь жилд хоёр удаа аймаг, нийслэлийн, аймаг, нийслэлийн бүртгэл, мэдээллийн сан нь жилд нэг удаа улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд тус тус тайлангаа хүргүүлнэ.

23.3.Монгол Улсын иргэн, хуулийн этгээд болон гадаадын байгууллага, иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын соёлын өвтэй холбоотой зүйлийг өөрийн санаачилгаар төрийн өмчид өгсөн тохиолдолд уг дурсгалыг соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд бүртгэж, түүнийг хадгалах үүрэг бүхий байгууллагад шилжүүлнэ.

## **24 дүгээр зүйл. Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн мэдээллийг ашиглах**

24.1.Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн мэдээллийг эрх бүхий этгээдийн зөвшөөрлөөр иргэн, хуулийн этгээдэд ашиглуулж болно. Мэдээллийг ашиглуулахдаа өмчлөгч, эзэмшигчийн хууль ёсны эрх ашгийг хөндөж үл болно.

24.2.Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд бүртгэгдсэн соёлын өвийн мэдээллээр нийтэд

зориулан сурталчилгааны хялбаршуулсан бүтээл гаргаж болно.

24.3.Соёлын биет өв алдагдсан тохиолдолд соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санг хариуцсан байгууллага холбогдох мэдээллийг хил, гааль, цагдаа, хяналтын байгууллагад нэн даруй хүргүүлэх арга хэмжээ авна.

## **ЗУРГААДУГААР БҮЛЭГ**

### **СОЁЛЫН ӨВИЙГ ЭЗЭМШИХ, АШИГЛАХ, ӨМЧЛӨХ**

#### **31 дүгээр зүйл. Соёлын биет өвийг эзэмших**

31.1.Нийтийн өмчийн соёлын биет өвийг төрийн болон орон нутгийн, шашны, олон нийтийн байгууллага өмчлөгчийн тогтоосон нөхцөлөөр тус тус эзэмшинэ.

31.2.Доор дурдсан байгууллага, хуулийн этгээд нийтийн өмчийн соёлын биет өвийг эзэмшинэ:

31.2.1.төрийн болон орон нутгийн музей;

*/Энэ хэсэгт 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./*

31.2.2.галерей;

31.2.3.эрдэм шинжилгээний байгууллага;

31.2.4.үндэсний болон аймаг, нийслэл, дүүргийн номын сан;

31.2.5.үндэсний төв архив, аймаг, нийслэлийн архив;

31.2.6.шашны байгууллага;

31.2.7.хууль тогтоомжоор соёлын өвийг хадгалж, хамгаалах үүрэг хүлээлгэсэн бусад байгууллага.

## **32 дугаар зүйл. Төрийн өмчийн соёлын биет өвийг эзэмшигчийн эрх, үүрэг**

32.1.Соёлын биет өвийг эзэмшигч дараах эрх эдэлнэ:

32.1.1.өмчлөгчтэй тохиролцсоны дагуу нийтэд дэлгэн үзүүлэх, сурталчлах, үзэсгэлэнд оролцуулах, түүнээс олсон орлогын тодорхой хувийг авах;

32.1.2.ангилал, зэрэглэлийг харгалзан холбогдох журмын дагуу тэдгээрийг түр солилцох, түрээслэх, худалдаж авах;

32.1.3.сурвалжлан олж цуглуулах, судалж шинжлэх, эрдэм шинжилгээний хурал, зөвлөгөөн, сургалт зохион байгуулах;

32.1.4.стандартын шаардлага хангасан байр, лаборатори, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангагдах;

32.1.5.соёлын биет өвийн загвараар бүтээгдэхүүн үйлдвэрлүүлэх.

32.2.Соёлын биет өвийг эзэмшигч дараах үүрэг хүлээнэ:

32.2.1.соёлын өвийн бүртгэл хөтөлж, бүртгэл, мэдээллийн сан үүсгэх;

32.2.2.дээд шатны бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлэх;

/Энэ заалтад "Соёлын" гэсний өмнө "харьяалах аймаг, нийслэлийн" гэж 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан бөгөөд 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

32.2.3.бүртгэл, мэдээллийн санд бүртгэгдсэн соёлын өвийн шилжилт хөдөлгөөний мэдээллийг бүртгэх;

32.2.4.түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг хилээр гаргахад зохих журмын дагуу зөвшөөрөл авах;

32.2.5.соёлын биет өв алдагдсан, үрэгдсэн тохиолдолд тухайн шатны бүртгэл, мэдээллийн сан, Засаг дарга, цагдаагийн байгууллагад нэн даруй мэдэгдэх;

32.2.6.өмчлөгчийн зөвшөөрөлгүйгээр соёлын биет өвийг сэргээн засварлах, бусдад ашиглуулахгүй байх.

### **33 дугаар зүйл. Соёлын биет өвийг өмчлөгчийн эрх, үүрэг**

33.1.Соёлын биет өвийг өмчлөгч иргэн, хуулийн этгээд дараах эрх эдэлнэ:

33.1.1.язгуур зориулалтаар ашиглах;

33.1.2.нийтэд дэлгэн үзүүлэх, сурталчлах, үзэсгэлэнд тавих, түүнээс олсон орлогоос авах;

33.1.3. зайлшгүй сэргээн засварлах шаардлагатай тохиолдолд зохих журмын дагуу улсаас санхүүгийн дэмжлэг авах;

33.1.4. түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг өөрийн хүсэлтээр төрд худалдсан тохиолдолд татварын хөнгөлөлт эдлэх;

33.1.5. музей, галерей байгуулах.

33.2. Соёлын биет өвийг өмчлөгч иргэн, хуулийн этгээд дараах үүрэг хүлээнэ:

33.2.1. соёлын өвийн гарал үүслийн байдлыг тодорхойлох;

33.2.2. харьяалах аймаг, нийслэлийн Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлэх;

/Энэ заалтад 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./

33.2.3. худалдах, бэлэглэх, өвлүүлэх зэргээр өмчлөх эрхээ бусдад шилжүүлсэн тохиолдолд тухайн шатны Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд мэдэгдэх;

33.2.4. түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг хилээр гаргахад зохих журмын дагуу зөвшөөрөл авах;

33.2.5. алдагдаж, үрэгдсэн тохиолдолд нэн даруй тухайн шатны Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан, Засаг дарга, цагдаагийн байгууллагад мэдэгдэх;



33.2.6.түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг худалдах анхны саналыг төрд тавих;

33.2.7.түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүнд бэлэглэх, өвлүүлэх зэргээр түүний өмчлөлд шилжүүлэхгүй байх.

### **35 дугаар зүйл. Соёлын биет өвийг худалдах, худалдан авах**

35.1.Соёлын биет өвийг түрээслэх, худалдах, худалдан авах, түр солилцох журмыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

35.2.Соёлын биет өвийг худалдан авах ажлыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, улс, орон нутгийн музей, номын сан олон нийтэд нээлттэй, ил тод хэлбэрээр зохион байгуулна.

*/Энэ хэсэгт 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

35.3.Соёлын биет өвийг худалдан авсан байгууллага жил бүр үзэсгэлэн зохион байгуулж, нийтэд сурталчилна.

35.4.Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүнд худалдахыг хориглоно.

35.5.Палеонтологи, археологийн олдворыг худалдахыг хориглоно.

## **36 дугаар зүйл.Соёлын биет өвийг ашиглах**

36.1.Соёлын биет өвийг сурталчлах, судалгаа, шинжилгээ, сургалт явуулах зориулалтаар ашиглана.

36.2.Соёлын биет өвийг сурталчлах, судалгаа, шинжилгээ хийх, сургалт явуулах зориулалтаар ашиглахдаа гэмтээх, үрэгдүүлэхийг хориглоно.

36.3.Төрийн өмчид байгаа соёлын биет өвийг язгуур зориулалтаар ашиглахыг хориглоно. Энэ хэсгийн заалт нь түүх, соёлын дурсгалт барилга, байшинд хамаарахгүй.

## **ДОЛООДУГААР БҮЛЭГ.**

### **СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТОГТОЛЦОО**

#### **37 дугаар зүйл.Соёлын өвийг хамгаалах тогтолцоо**

37.1.Соёлын өвийг хамгаалах асуудлыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага болон бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, энэ хуулиар үүрэг хүлээсэн байгууллага, эрх бүхий этгээд хариуцна.

/Энэ хэсэгт 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

37.2.Соёлын өвийн хамгаалалтад соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага, бүх шатны Засаг дарга, соёлын өвийн хяналтын улсын байцаагч,

гэрээт харуул, хуулиар эрх олгосон байгууллага, албан тушаалтан хяналт тавина.

/Энэ хэсэгт 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

37.3.Соёлын өвийн анхны төрх, нэгдмэл цогц байдлыг алдагдуулахгүйгээр тухайн орон нутагт нь хадгалах зарчим баримтална. Хадгалалт хамгаалалтын нөхцөлийг сайжруулах зорилгоор соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний зөвшөөрлөөр төрийн болон, орон нутгийн музейд шилжүүлэн хадгалж болно.

/Энэ хэсэгт 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

37.4.Сум, дүүргийн Засаг дарга түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах үүргийг гэрээний үндсэн дээр иргэн, хуулийн этгээдээр гүйцэтгүүлж болно.

37.5.Улс, аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын дэргэд тухайн дурсгалын талаарх мэдээллийг агуулсан танилцуулга, тайлбар, тэмдэг, тэмдэглэгээ байрлуулна. Танилцуулга, тайлбар, тэмдэг, тэмдэглэгээг стандартын дагуу хийж, байрлуулах ажлыг аймаг, нийслэлийн Засаг дарга хариуцан зохион байгуулна.

37.6.Аймаг, нийслэлийн Засаг дарга хот, суурин газарт орших түүхэн дурсгалт барилга,

архитектурын дурсгалын харагдах сүр барааг хадгалах зорилгоор түүний эргэн тойронд шинээр барих барилга байгууламжид өндрийн хязгаар тогтооно. Өндрийн хязгаар тогтоох шалгуур үзүүлэлтийг хот байгуулалтын болон соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

/Энэ хэсгийг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар нэмсэн./

### **38 дугаар зүйл.Соёлын өвийг хамгаалахтай холбоотой хориглох үйл ажиллагаа**

38.1.Соёлын өвд хохирол учруулж болзошгүй дараах үйл ажиллагааг хориглоно:

38.1.1.түүх, соёлын дурсгалт газар түүний орчны бүсэд дэд бүтцийн барилга байгууламж барих, уул уурхай, газар тариалан эрхлэх, үйлдвэрлэл явуулах;

38.1.2. палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэхгүйгээр хот суурин, барилга байгууламж барих, шинээр зам тавих, тариалангийн талбай олгох, усан цахилгаан станц байгуулах, ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахад зориулж газар олгох;

38.1.3.хуульд зааснаас бусад тохиолдолд нийтийн өмчийн түүх, соёлын хөдлөх дурсгалт

зүйлийг өмчлөгчийн зөвшөөрөлгүйгээр өөр байгууллага, орчинд шилжүүлэн хадгалах, зөөж тээвэрлэх, хөдөлгөх;

38.1.4.улс, аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалд зар сурталчилгааны самбар, бичиг хадах, анхны хэлбэр төрх, хийц, бүтээцийг өөрчлөх.

38.2.Палеонтологи, археологи, угсаатны урьдчилсан хайгуул, судалгааны ажлын дүгнэлтээр соёлын өвд эрсдэл учирч болзошгүй байгаа нь тогтоогдсон бол аж ахуйн үйл ажиллагааг зогсоох үндэслэл болно.

38.3.Газрын хэвлийг эзэмших, ашиглах явцад соёлын биет өв илэрвэл газрын хэвлийг ашиглагч ажлаа зогсоож, энэ тухай сум, дүүргийн Засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг хариуцсан байгууллагад нэн даруй мэдэгдэнэ.

## **АРАВДУГААР БҮЛЭГ.**

### **СОЁЛЫН ӨВИЙГ СУРТАЛЧЛАХ**

#### **49 дүгээр зүйл.Соёлын өвийн боловсрол**

49.1.Соёлын өвийн талаарх мэдлэг олгох, түүнийг хамгаалах, сурталчлах арга хэмжээг гэр бүлийн соёл, хүмүүжлийн уламжлал болон боловсролын тогтолцоогоор дамжуулан хэрэгжүүлнэ.

49.2.Соёлын өвийн боловсрол эзэмшүүлэх ажлыг дараах байдлаар зохион байгуулна:

49.2.1.соёлын өв, түүнийг хамгаалах мэдлэгийг сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн боловсролын сургалтын стандартад тусгах;

49.2.2.коллеж, их, дээд сургууль болон мэргэжлийн сургалтын байгууллагын суралцагчид соёлын өвийг хамгаалах, ашиглах талаар шинжлэх ухааны үндэслэлтэй боловсрол эзэмшүүлэх;

49.2.3.олон нийтэд хэвлэл, мэдээллийн хэрэгслээр соёлын өвийг хамгаалах, өв уламжлал, ёс заншил, хууль тогтоомжийг сурталчлан таниулах.

## **50 дугаар зүйл.Соёлын өвийн үзэсгэлэн**

50.1.Төрийн болон орон нутгийн өмчийн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлээр гадаадад үзэсгэлэн гаргах ажлыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрх олгосон байгууллага зохион байгуулна. Энэ заалт хувь хүн, хуулийн этгээд хувийн өмчийн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлээр гадаадад үзэсгэлэн гаргахад хамаарахгүй.

/Энэ хэсгийг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

/Энэ хэсэгт 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

50.2.Энэ хуулийн 50.1-д заасан эрх бүхий байгууллага соёлын биет өвийг эзэмшигчтэй гэрээ байгуулна. Гэрээнд биет өвийг ашиглах нөхцөл, хугацаа, даатгалын баталгааны хэмжээ, түрээсийн төлбөр, ашиглагч этгээдийн хүлээх хариуцлага, хамгаалалтын болон эрсдэлийн баталгааны нөхцөлийг тусгана.

50.3.Хувийн өмчийн соёлын өвийг өмчлөгч, эзэмшигчтэй нь байгуулсан гэрээний үндсэн дээр үзэсгэлэнд оролцуулж болно.

50.4.Соёлын биет өвийг гадаадад үзэсгэлэнд гаргах гэрээг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хянана.

50.5.Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлээгүй палеонтологи, археологийн олдвор, дурсгалаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллага үзэсгэлэн гаргах, музей байгуулахыг хориглоно.

хуулиар хүчингүй болсонд тооцсон бөгөөд 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

З.ЭНХБОЛД

## **БАРИМТАТ ӨВИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ**

Баримтат өв хэмээх ойлголт нь түүхэн тодорхой орон зай, цаг үеийн аль нэг хэсгийг төлөөлж чадах байгаль, нийгэм, түүх, соёл, урлаг, шинжлэх ухааны үнэ цэн, ач холбогдол бүхий мэдээлэл агуулсан төрөл бүрийн эд материал дээр бичсэн ном бичгийн зүйл, дуу, дүрсээр баримтжуулан үлдээсэн өв дурсгалыг хамааруулан ойлгож болох юм. Баримтат өвийн хадгалан тээж ирсэн мэдээллийн ач холбогдол, үнэ цэнийг тогтооход тодорхой газар нутаг, орон зай, цаг хугацаа, бүтээгч, өвийн ур хийц хамгийн гол зүйл мөн.

Энэ утгаараа Монголын болоод бүс нутгийн, дэлхийн түүхэнд онцгой ач холбогдолтой газар нутгийн талаар маш ховор, шийдвэрлэх мэдээ мэдээллийг агуулж байж ч болно. Эсвэл, тухайн өвийг бүтээсэн газар нутаг нь уг өвд гарч байгаа үйл явдал нь нийгмийн үзэгдлүүдэд онцгой нөлөө үзүүлсэн ба тэрхүү өвийн агуулга нь үгүй болсон соёл иргэншил, зан заншил, тэр үеийн төр улс, нийгмийн харилцааны талаар, тэдгээрийн дүр төрхийг дүрслэн бичсэн байвал баримтат өвийг онцгой анхаарч үзнэ.

Баримтат өв бол монголын түүх, соёлын салбарт хамгийн түгээмэл байдаг боловч, өргөн утгаараа харьцангуй ойлголт юм. Цаасан дээр



бичиж тэмдэглэн үлдээсэн баримтын зэрэгцээ 1820 оны эхээр шинжлэх ухааны ололт, техник технологийн дэвшилд тулгуурласан гэрэл зураг, 1895 оноос кино болон дуу авианы технологи, улмаар 1970-аад оноос дүрс бичлэгийн технологи дэлгэрч эхэлсэн нь баримтат өвийн тухай ойлголтыг нэмэгдүүлсээр байна.

Тухайн баримтат өв нь нөлөө бүхий түүхэн хувь хүмүүс, үндэстэн, угсаатан, нийгмийн бүлгүүдийн хэв маягийг тусгасан төдийгүй тухайн цаг үед болж байсан хөгжил дэвшил, хямрал, нийгмийн болон соёлын томоохон өөрчлөлтүүдийн цаг үеийг онцгой ховор илтгэн харуулсан ч байдаг. Гэвч эдгээр өв нь шинэ нээлтийг төлөөлөх юм уу, эсвэл тэр төрлийн бүтээлийн анхдагч ба сүүлийн төлөөлөл байж болох уу? гэдгийг нарийн сайн тогтоох шаардлага урган гарна.

Баримтат өв нь бусад төрөл хэлбэрийн бүх өвийн дотроос илүү тодорхой, дэлгэрэнгүй, асар их мэдээллийг багтаасан байх учир хүн төрөлхтний дурсамжийг хадгалах, хойч үед өвлүүлэн эзэмшүүлэх, өнгөрсөн үеийн түүхийг илүү үнэн бодитойгоор гэрчлэн нотлоход юугаар ч орлуулашгүй бөгөөд үнэлж баршгүй ач холбогдолтой юм. Баримтат өв нь бичиг үсэг, дүрс дуу авианы бичлэгийн гэх мэт олон арга

хэлбэрээр баримтжин үлддэг соёлын хөдөлгөөнт төрөл бөгөөд тухайн улс орны түүх, хэл, соёл, зан заншлын тухай мэдээллийг хадгалж байдаг соёлын болоод судалгаа шинжилгээний чухал хэрэглэгдэхүүн юм. Бусад төрлийн өвүүдээс илүү тодорхой, дэлгэрэнгүй, асар их мэдээллийг багтаасан байдаг учир тухайн үндэстний түүх, соёлыг бодитойгоор гэрчлэн нотлоход чухал ач холбогдолтой ба Соёлын биет болон биет бус өвийн аль алиных нь шинжийг агуулсан байдаг.

## БАРИМТАТ ӨВИЙН ТӨРӨЛ ЗҮЙЛ

Баримтат өвийн төрөл зүйл хэмээх ойлголтыг хоёр янзаар ойлгож болно. Үүнд:

1. “Баримтат өв”- ийг ямар төрлийн материал дээр ямар аргаар бүтээн баримтжуулж байгаагаас хамааран баримт мэдээллийг агуулан тээгч нь олон төрөл зүйл байдаг байна. Бичиг үсгээр цаас, мод, хад чулуун дээр бичиж, сийлэхээс эхлээд тоон технологийн мэдээлэл хүртэл баримтат өвийн олон төрлийн тээгч хэрэгслүүдийг хүн төрөлхтөн бас бүтээсэн байна.
2. Баримтат өвийг мэдээллийн агуулгаар нь төрөл зүйлд ангилан хувааж болох юм. Тухайн баримтат өвийн мэдээллийг шинжлэх ухааны агуулгаар нь ёс заншил, зан үйл, амьдралын арга ухааны мэдлэг агуулсан уу? Гэдгийг сайтар тогтоосноор төрөл зүйлд хувааж болох юм. Энэ утгаараа баримтат өв нь соёлын биет бус өвийг баримтжуулан туурвисан өв байх нь элбэг. Иймээс бид баримтат өвийн талаар үзэл, ойлголтоо нэгтгэсний үндсэн дээр баримтат өвийн төрөл зүйлийг нь сайтар ялгаж мэддэг байх ёстой болоод байгаа тул баримтат өвийн мэдээллийг ямар материал *(баримтат өвийн мэдээлэл тээгч)*

дээр бүтээснийг доорх байдлаар төрөлжүүлэн хувааж болох юм.

- Цаас
- Мод, үйс, навч
- Хад чулуу
- Илэг, арьс, шир, яс
- Торго, бөс даавуу
- Металл дээр бүтээсэн баримтат өв г.м.

Үүнээс гадна аудиовизуаль баримтат өв, гэрэл зургийн хальс, микрофильм, микрофиш, аудио, видео хуурцаг, пянз, хуурцаг /кассет/, CD, DVD, Flash, HARD зэрэг. Эдгээрээс өөр бусад зүйл дээр бүтээсэн байхыг үгүйсгэхгүй.

Эдгээр баримтат өвийн мэдээллийг ямар төрлийн материал дээр (*мэдээлэл тээгч*) баримтат өвийг бүтээж байсныг дараах байдлаар харж болох юм.

**Цаасан** дээр бүтээсэн баримтат өв нь төрөл бүрийн цаасан дээр зурж тэмдэглэн бичсэн гар бичмэл байхаас гадна барласан судар ном буюу өндөр хэвлэлийн болон оффсет хэвлэлийн аргаар хэвлэсэн, бичгийн машинаар бичиж тэмдэглэсэн дурсгалыг хамааруулан ойлгож болно.

**Модон** дээр бүтээсэн өв нь ном судрын бар, модон дээр үйл явдлын дүрслэлийг зурж

тэмдэглэсэн, мэдээллийг бичсэн өвийг хамааруулна. Тухайлбал: “Мэргэд гарахын орны модон бар”. Энэ өв бол Монголчуудын ном хэвлэлийн технологийн мэдлэг ухааныг сэргээсэн өвийн том төлөөлөл төдийгүй бүтээгдсэн түүхэн он цаг, үйл явц нь Судар бичгийн хүрээлэнгийн баримтаар нотлогддог. Орос хэвлэлийн үйлдвэр монголд орж ирснээс арваад жилийн дараа уламжлалт аргаар бүтээсэн онцлог түүхтэй юм.

**Хад чулуун** дээр бүтээсэн баримтат өвд Судар номын бар, гэрэлт хөшөө, хадны бичээс, тамга тэмдгийн зүйлийг оруулж болно. Энэ төрлийн өв нь хөдлөх, болон үл хөдлөх өвийн шинжийг агуулж байдаг өвөрмөц өв юм. Тухайлбал: “Чингэсийн чулууны бичиг”, “Цогтын хадны шүлэг”, “Данжуурын гэрэлт хөшөө” гэх мэт олныг дурдаж болно.

**Үйс, навчин** дээр бүтээсэн баримтат өв нь харьцангуй ховор төрлийн байж болно. Энэтхэг зэрэг оронд дал модны навчин дээр бичих явдал эрт үед элбэг байжээ. Харин Монгол оронд хус модны үйсэн дээр бичиж байв. Үүний томоохон төлөөлөл нь Хар бухын балгаснаас олдсон үйсэн номууд болно. Энэ төрлийн өвийн агуулж ирсэн мэдээллийн ач холбогдол, он цагийн байдлыг анхаарах нь чухал. Харин мэдээлэл бүрэн бүтэн эсэх нь эргэлзээтэй байж болно.

**Арьс, шир илгэн** дээр бүтээсэн баримтат өв. Монголчуудын арьс, шир, илгэн дээр бүтээсэн дүр дүрслэлийн бүтээлүүд байх ч мэдээлэл үлдээсэн баримтат өв тун ховор. Европын орнууд илгэн болон цаасан өвийн асар их уламжлалтай. Гэхдээ энэ төрлийн өв олдож болохыг үгүйсгэхгүй юм.

**Ясан** дээр бүтээсэн баримтат өв. Энэ төрлийн баримтат өв тийм ч элбэг биш. Монголд бог малын далны ясан дээр маанийн үсэг бичсэн байх боловч үүнийг баримтат өв гэхэд хэцүү. Баримтат өв бол ямартай ч мэдээлэл агуулсан байх ёстой гэдэг зарчмыг бодолцох нь зөв.

**Торго, бөс даавуун** дээр бүтээсэн баримтат өв. Энэ төрлийн баримтат өв манайд элбэг байдаг өвүүдийн нэг юм. Торгон дээр ихэвчлэн өргөмжлөлийн баримт, газар нутгийн зураг, угийн бичиг, хүрээ хийдийн жаяг байхаас гадна торгон өргөмжлөлийн тухайд энэхүү өргөмжлөлийг олгох болсон шийдвэр, эх зохиогч, болон бичээчийн цаасан тэмдэглэл хамт байх аваас хамгийн ач холбогдол бүхий өв болох юм.

Тамга, тэмдэг, дардас, мутрын тэмдгийн зүйл нь металл, мод, чулуун дээр бүтээсэн байдаг. Тухайлбал: Халхын Түшээт сайн ханы тамга. Өндөр Богд гэгээнтний шүншиглэж, үе улиран тахиулсаар лүндэн буулгасан ёсоор

Түшээт сайн хан Доржсүрэнхоролжав барьж байсан тухай түүхийг нь баримтаар нотолж болох өв. Монголчуудын тамганы өв соёлын томоохон төлөөлөл мөн. Тамганы төрлийн өв дурсгалууд үндэсний хэмжээнд бахархалт өв байж болно.

### **Кино, дуу дүрсний баримтат өв**

Дүрс, дуу авианы мэдээллийг тусгай тоног төхөөрөмжийн тусламжтайгаар бичих, сонсох, харж болох аналог технологи ашиглан үүссэн аудиовизуаль баримт нь бусад төрлийн өвүүдээс өвөрмөц ялгаатай ч хөдөлгөөнт болон хөдөлгөөнт бус дүрс, дуу авиаг буулгасан баримтыг гэрэл зураг болон гэрэл зургийн хальс, микрофильм, микрофиш, аудио, видео хуурцаг, пянз, CD, DVD, Flash, HARD зэрэг тээгчид буулгадаг. Дүрс, дуу авианы мэдээллийн ач холбогдол нь ямар вэ? гэдгээс хамаарч үндэсний өвд бүртгэнэ. Энэ төрлийн өвийг бусад төрлийн өвүүдтэй ижил шалгууртай.

**Төрөл бүрийн металл** дээр бүтээсэн баримтат өвд судар номын бар, ихэс дээдсийн алтан өргөмжлөл, тамга тэмдгийн зүйл гэж ангилж болно.

## **БАРИМТАТ ӨВИЙН АГУУЛГЫН АНГИЛАЛ**

Баримтат өв ямар материал дээр бүтээгдсэнээс үл хамааран мэдээллийн агуулгын үнэ цэн, ач холбогдол чухал юм. Ном судар, гар бичмэл байвал бүтээгч, зохиогчийн мэдээлэл, үүх түүх, мэдээллийн агуулгаар ангилал гаргавал баримтат өвийн үнэ цэнийг зөв тодорхойлж болно. Тухайлбал: Судар номын тухайд зохиогч, зохиогдсон газар орны мэдээлэл буюу ном судрын төгсгөлийн үг асар их мэдээлэл хадгалж байдгийг анхаарна уу.

Монгол Улсын баримтат өвд нэр дэвшүүлэх өв нь барласан төвөд, монгол судар, гар бичмэл байвал тэр нь Бурхны шашинт Монголчуудын сүсэг бишрэл, буян өргөл, ур ухааны хосгүй үнэт бүтээл, бичиг соёл, уран зургийн гайхалтай зохицол нийлэмж, урлахуйн уламжлалт нууц арга ухаан, эрдэнэс ашиглан цогцоор нь шингээсэн байж болно. Энэ утгаараа монголын оюун санааны давтагдашгүй өв дурсгал болохыг тухайн баримтат өвийн агуулгаар нь дараах байдлаар ангилж болно. Үүнд:

1. Хөлгөн судар
2. Бүрэн зохиол
3. Түүх, намтар зохиол
4. Анагаах ухаан
5. Зурхай, мэргэ, шинжээ, үзлэг



6. Толь бичиг, хэл шинжлэл

7. Данс бүртгэл, товъёг, гарчиг

8. Уншлага, гүрэм засал, зан үйлийн холбогдол бүхий агуулгатай судар ном манайд маш элбэг энэ 8-р ангилалыг ерөнхийд нь нэг төрөл зүйл болгож боловч доорх байдлаар доторх мэдээллийн ач холбогдолоор нь нарийвчлан ангилж болно. Эдгээр ангилал нь ихэвчлэн монгол, төвөд судлал өндөр хөгжсөн улс орнууд энэ төрлийн судар номыг дижитал каталог, вэб сайт хөгжүүлэхдээ ихэвчлэн ашигладаг. Эдгээр төрлийн том, жижиг судар номууд монголчуудын амьдрах арга ухаан, зан үйлийн хэв маягийг тусгасан байдгаараа маш өвөрмөц бичиг соёлын өвд хамаардаг онцлогтой. Үүнд:

- 8.1. Тогтоол тарни
- 8.2. Сан сэржим
- 8.3. Хариулга засах арга
- 8.4. Даллага
- 8.5. Аравнай
- 8.6. Ариутгах зан үйл
- 8.7. Ерөөл
- 8.8. Тайлбар
- 8.9. Хөтөлбөр
- 8.10. Соёрхол
- 8.11. Угаал
- 8.12. Мандал өргөх ёс

- 8.13. Тахил
- 8.14. Магтаал
- 8.15. Балин
- 8.16. Наманчлал, Хангал
- 8.17. Зан үйл гарын авлага
- 8.18. Бүтээх арга
- 8.19. Гүрэм
- 8.20. Золиг гаргах
- 8.21. Увдис
- 8.22. Асуулт хариулт, захидал
- 8.23. Ая дан
- 8.24. Зуурдын номлол.

Гэхдээ эдгээр төрлийн өвийн агуулга нь онцгой ач холбогдолтой газар нутгийн талаар болон зан үйлийн маш ховор, шийдвэрлэх мэдээ мэдээллийг агуулсан эсвэл, тухайн номыг бүтээсэн газар нутаг нь уг номд гарч байгаа үйл явдал болоод үзэгдлүүдэд онцгой нөлөө үзүүлсэн эсэх. Энэ ном, баримт нь үгүй болсон сүм хийд болон тухайн үеийн төр улс, нийгмийн харилцааны талаар, тэдгээрийн дүр төрх, соёл зан үйлийн талаар дүрслэн бичсэн байвал заавал баримтат өвийн бүртгэлд авах хэрэгтэй. Ингэхдээ тухайн судар номын төгсгөлийн үгийн мэдээнд тулгуурлана.

Баримтат өвийг олж тогтоохдоо зөвхөн он цагаар үнэ цэн, ач холбогдлыг тодорхойлж болохгүй. Тухайн өв нь тухайн цаг үеийнхээ бүтээгдэхүүн байдаг. Энэхүү арга зүйн зөвлөмжийн “Монгол улсын баримтат өвийн бүртгэл”-д нэр дэвшүүлэх дурсгалыг таньж тогтоох шалгуур үзүүлэлтийн ажлын даалгаварыг анхааралтай судлан үзэж, бүртгэлийн маягтыг үйлдэнэ.

Хувь хүн, өмчилж буй өвийг “Монгол Улсын баримтат өвийн бүртгэлд” оруулахаар нэр дэвшүүлсэн бол юуны урьд жинхэнэ эх мөн үү гэсэн шалгуурыг хангаж байгаа эсэхийг үнэлэн тогтоогоод шалгуурын маягтыг бөглөөд сумын БМСанд хүргүүлнэ /Шаардлагатай гэж үзвэл аймгийн болон СӨУНБМС-д хүлээлгэн өгч болно/. Ингэхдээ: Монгол Улсын баримтат өвийн бүртгэлд нэр дэвшүүлэх өвийг бүртгэх маягтын шалгуур асуулгын дагуу утгын дарааллыг алдагдуулахгүйгээр Excel template суурьтай бүртгэлийг бүрдүүлэлт хийж дээрх шалгуур үзүүлэлтийг үндэслэн шалгуур асуулт бүрд хариулт өгсөн байна. Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн дөрөвдүгээр бүлгийн 20 зүйлийн 20.7, 20.8 заалтыг хэрэгжүүлж ажиллана.

“Монгол Улсын баримтат өвийн бүртгэлд” нэр дэвшүүлж буй өвийн зураг хавсаргасан байна.

“Монгол Улсын баримтат өвийн бүртгэлд” оруулах өвийг нэр дэвшүүлсэн баримт бичгийг бэлтгэхэд шаардлагатай бусад мэдээллийг СӨҮТ-ийн Бүртгэл мэдээллийн газраас авч болно.

# “МОНГОЛ УЛСЫН БАРИМТАТ ӨВИЙН БҮРТГЭЛ”-Д НЭР ДЭВШҮҮЛЭХ ДУРСГАЛЫГ БҮРТГЭХ АРГАЧЛАЛ

## 1. Нийтлэг үндэслэл, зорилт

1.1. ЮНЕСКО-оос дэлхийн түүх, хүн төрөлхтний соёл иргэншилд онцгой нөлөө үзүүлсэн, дэлхийн улс орны түүхийн дурсамж, ой санамжийг илэрхийлэх “баримтат өв”-д хамаатах түүх, соёлын дурсгал, эд өлгийн зүйлийг тусгайлан бүртгэж, тэдгээрийг хадгалж, хамгаалах зорилгоор “Дэлхийн дурсамж” хөтөлбөрийг 1992 оноос эхлүүлжээ.

1.2. DOCUMENTARY-HERITAGE REGISTRATION-FORM Excel template суурьтай бүртгэл нь (цаашид Баримтат өвийн бүртгэл гэх) Монгол Улс дахь нийтийн болон хувийн өмчийн эзэмшил, өмчлөлд хадгалагдаж буй соёлын биет өв болох түүх, соёлын үл хөдлөх болон хөдлөх дурсгалт зүйлээс баримтат өвийн урьдчилсан жагсаалтад бүртгэх, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тоон дүнг нэгтгэх, баримтат өвийн тусгай тусгай бүртгэлийн программ бий болоход

шаардлагатай анхдагч мэдээллийг цуглуулахад оршино.

- 1.3. Баримтат өвийн бүртгэлд хамаатах соёлын өв нь дэлхийн түүх, хүн төрөлхтний соёл иргэншилд онцгой нөлөө үзүүлсэн, дэлхийн улс орны түүхийн дурсамж, ой санамжийг илэрхийлэх үнэ цэнтэй байна.
- 1.4. Нэр дэвшиж буй дурсгал, эд өлгийн зүйл нь эх хувилбараар (оргиналь) байна.
- 1.5. Улс, аймгийн музей, судалгааны байгууллагад хадгалагдаж буй эд өлгийн зүйлсийг шат шатны бүртгэл мэдээллийн сангийн төлөөлөл; хувийн өмчлөлд буй эд өлгийн зүйлсийг тухай өмчлөгч иргэн хуулийн этгээд нь бүртгэл мэдээллийн сангийн төлөөлөл болон холбогдох захиргааны байгууллагаас эрх олгосон хүнтэй хамтарч хийнэ.

## **2. Аргачлал**

### **2.1. Өмчлөгч**

Нийтийн өмчийн баримтат өвийг бүртгэж буй бол “Монгол Улс” гэж бичнэ. Харин хувийн өмчийн баримтат өвийн өмчлөгч нь хувь хүн бол өөрийн нэр (Овгийн эхний үсэг) регистрийн дугаарын

хамт бичнэ. (Жишээг DOCUMENTARY-HERITAGE-REGISTRATION-FORM-ын “Жишээ” tab-аас харна уу).

## 2.2. Эзэмшигч

Эзэмшигчийн нэрийг бичнэ. Хэрэв нийтийн өмчийн баримтат өвийг бүртгэж буй бол (улс, аймгийн музей) нь харьяалах засаг захиргааны нэгж, байгууллагын нэрийг бичнэ. Хувь хүний эзэмшлийн баримт өв бол овог, нэр, регистрийн дугаарыг бичнэ (Жишээг DOCUMENTARY-HERITAGE-REGISTRATION-FORM-ын “Жишээ” tab-аас харна уу).

## 2.3. Баримтат өвийн нэр

Баримтат өвийн нэрийг бичнэ. (Жишээг DOCUMENTARY-HERITAGE-REGISTRATION-FORM -ын цэсээс харна уу).

## 2.4. Хувийн дугаар

Улс, аймгийн музей, ОНС танхим нь үзмэрийн хувийн дугаарыг бичнэ. Хувийн өмчлөлийн этгээд бүртгэлийн дугаартай бол бичих, дугааргүй бол хоосон орхино. Түүх, соёлын үл хөдлөх дурсгал бол RICH программд орсон бүртгэлийн дугаарыг

бичих ба ийм дугаар байхгүй бол хоосон орхиж болно.

## 2.5. Баримтат өвийн төрөл

Дараах 16 төрлөөс аль төрөлд тохирохыг сонгохдоо DOCUMENTARY-HERITAGE-REGISTRATION-FORM-ын “Заавар” цэсээс тохирохыг сонгоно. Сонгохдоо гараар бичихгүй ба компьютерын гарын тусламжтайгаар (copy past) хуулж тохирох нүдэнд бөглөнө.

1. Баримт бичиг
2. Гар бичмэл
3. Ном, сонин
4. Зоос, мөнгөн тэмдэгт
5. Марк, ил захидал
6. Дуу, дүрс бичлэг
7. Гэрэл зураг
8. Туг, тамга тэмдэг
9. Хүн чулуу
10. Гэрэлт хөшөө
11. Хадны зураг, бичээс
12. Танка, монгол зураг
13. Даавуу, зөөлөн эдлэл
14. Бар, дардас
15. Судар ном
16. Бусад



## 2.6. Холбогдох он цаг

Соёлын биет өвийн түүхэн холбогдох он цаг, үеийг тодорхой бол бичих тодорхойгүй бол хоосон орхиж болно.

## 2.7. Хэмжээ

Урт, өндөр, өргөн, диаметрийн хэмжээ болон жинг метр, килограммд шилжүүлж бичнэ. Жинг хэмжих боломжгүй бол багцаа тоогоор бичиж болно (Жишээг DOCUMENTARY-HERITAGE-REGISTRATION-FORM-ын цэсээс харна уу).

## 2.8. Товч тодорхойлолт

Энэ хэсэгт соёлын биет өвийн харагдах шинж байдал, иж бүрдэл зэргийг 2-3 өгүүлбэрт багтаан бичнэ.

## 2.9. Шалгуур 1.

**Монгол төрт ёсны түүх, холбогдох засаг захиргаа, түүхэнд холбогдох үйл явдлыг тэмдэглэсэн, гэрчилсэн байх.**

Тухайн дурсгал, эд өлгийн зүйл нь Монголын төр, засаг захиргааны нэгжийн таних тэмдэг болсон бүх цаг үеийн тамга, тэмдэг, туг, зарлиг зэрэг болон түүхийн онцгой үйл явдлыг бичин тэмдэглэсэн түүхийн ном судар, бичээс, гэрэл зураг, дуу, дүрс бичлэг зэргийг хамаатуулан ойлгож болно.

#### 2.10. Шалгуур 2.

**Амьдрах ёс, соёл, шинжлэх ухааны үнэ цэнтэй бүтээл байх.**

Монгол үндэстэн, угсаатны амьдрах өвөрмөц соёл, байгаль эх дэлхий, ертөнцийг таньж мэдэх арга ухааныг тэмдэглэсэн, дүрсэлсэн дурсгалын төрөл зүйл, эд өлгийн зүйлийг хамаатуулан ойлгож болно.

#### 2.11. Шалгуур 3.

**Түүхэн үйл явдал, газар нутаг, уул усны түүхэн нэр дурдагдсан, байгаль, барилга байшин зэргийг тэмдэглэсэн, дүрсэлсэн байх.**

Монгол Улс, аймаг орон нутгийн байгалийн болон түүхэн газар нутаг, уул, овоо, гол мөрөн, тухайн бүс нутагт болсон

түүхэн үйл явдал, барилга архитектурын дурсгал зэргийг тэмдэглэсэн, дүрсэлсэн дурсгалын төрөл зүйл, эд өлгийн зүйлийг хамаатуулан ойлгож болно.

#### 2.12. Шалгуур 4.

**Олон улсын болон бүс нутаг, Монгол Улс, аймаг орон нутгийн алдар цуутай түүхэн хүнтэй холбогдсон байх.**

Олон улсад болон Монгол Улсад нэр хүнд, алдар цуутай түүхэн хүний улс төр, соёл, шинжлэх ухаанд хувь нэмэр оруулсан түүхэн үйл явдлыг илэрхийлэх эх гар бичмэл, амьдрал ахуйг харуулсан гэрэл зураг, дүрс бичлэг болон тэмдэглэсэн, дүрсэлсэн дурсгалын төрөл зүйл, эд өлгийн зүйлийг хамаатуулан ойлгож болно.

#### 2.13. Хадгалалтын байдал

Соёлын биет өвийн эвдрэл, гэмтэл, хадгалалтын байдлыг харгалзан үзэж сайн, дунд, муу гэсэн 3 үзүүлэлтээр бичнэ.

#### 2.14. Бүртгэсэн огноо

Нэр дэвшиж буй дурсгал, эд өлгийн зүйлийг бүртгэсэн цаг хугацааг он , сар,

өдөр (YYYY.MM.DD) гэсэн дарааллаар бичнэ.

2.15. Бүртгэсэн ажилтан: /Албан тушаал, нэр/

Улс, аймгийн музей, ОНС танхим, засаг захиргааны нэгжийн албан тушаалтан бол албан тушаал, овгийн эхний үсэг, нэрээ бичнэ. Хувь хүн бол овгийн эхний үсэг нэрээ бичнэ.

3. Бусад

3.1. Энэхүү Excel template суурьтай бүртгэлийг бүрдүүлэлт хийж буй тухайн засаг захиргааны нэгж нь маягтыг хэрэглэхдээ дангаар нь болон тус тусад нь салангид аль ч хэлбэрээр ашиглаж болно.

Баримтат өв болон түүнийг нэр дэвшүүлэх болсон гол үндэслэл шалтгааныг тодорхойлсон товч тайлбар дүгнэлт юм. Энэхүү нэр дэвшүүлсэн баримт бичгийг шаардлага хангасан, хангаагүйг эндээс харах болно. Энэ нь гол гол мэдээллийг хялбар ойлгогдохоор тоймлон дүгнэхэд тун чухал юм. Нэр дэвшүүлсэн өв үндэсний хэмжээнд нөлөөтэй эсэхийг энэ маягтаас харах болно.

“Монгол Улсын баримтат өвийн бүртгэл”-д нэр дэвшүүлсэн өвийн маягт, шалгуурыг бэлтгэж


боловсруулах, маягтыг бөглөх заавар зөвлөмжийг дээр өгөв. шаардлагатай нэмэлт мэдээллийг Соёлын өвийн үндэсний төвийн бүртгэл судалгааны газраас авч болно.

Нэр дэвшүүлэх баримт → бичгийг бэлтгэж боловсруулахын өмнө доорх “Монгол улсын баримтат өвийн бүртгэл”-д нэр дэвшүүлэх дурсгалыг таньж тогтоох шалгуур үзүүлэлтийн ажлын даалгавар бичих зөвлөмжийг сайтар уншиж судлаарай. Утгын дарааллыг алдагдуулахгүйгээр, шаардлагатай мэдээллийг оновчтой боловсруулна. Нэр дэвшүүлж буй баримтат өв бүх шалгуурыг давах албагүй тухайн өвд холбогдох шалгуурыг бичиж болно. “Монгол улсын баримтат өвийн бүртгэл”-д нэр дэвшүүлэх дурсгалыг бүртгэх аргачлалыг <http://ncch.gov.mn/> ТАТАХ, МЭРГЭЖИЛ АРГА ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ хэсгээс татаж авна. Бүртгэлийг И-мэйл: [burtgel@ncch.gov.mn](mailto:burtgel@ncch.gov.mn) хаягаар, цаасан хувилбарыг Хан-Уул дүүрэг 21-р хороо, Буянт Ухаа 2 хороолол, Соёлын Өвийн Үндэсний Төв хаягаар тус тус ирүүлнэ.


Утас: 7777-9004, 99123896

Баримтат өвийг бүртгүүлэхэд ажиллах хэсэг






Excel template суурьтай бүртгэлийн шалгуурын тайлбар хэсэг  
Зураг 3.



Excel template суурьтай бүртгэлийн хэсэг  
Зураг 4.



Excel template суурьтай бүртгэлийн шалгуур хэсэг  
Зураг 5.

## Баримтат өвийг олж тогтооход юуг анхаарах вэ?

“Монгол Улсын баримтат өвийн бүртгэлд” нэр дэвшүүлэх өвийг сонгон шалгаруулахдаа урьд нь олон улсын болон Ази-Номхон далай бүс нутгийн өвийн бүртгэлд орсон болон орж чадаагүй өвүүдтэй харьцуулан үзэж, баримтат өвийг сонгох шалгууруудыг хангаж буй эсэхийг харгалзан үзнэ.

Баримтат өв яг тийм байна гэсэн төгс шалгуур одоогоор байхгүй боловч олон улсад баримтат өвийг нэгийг нөгөөтэй харьцуулах байдлаар шалгаруулдаг асар их туршлага байгаа гэдгийг



анхаарна уу. Иймээс музей, номын сангийн бүртгэл, мэдээллийн санч нар баримтат өвийг олон улсын шалгаруулалтын зарчмаар өөрийн байгууллагын сан хөмрөгт байгаа бичиг соёлын өвүүдийг нэгийг нөгөөтэй харьцуулж мэдээллийн агуулга, ач холбогдол, ур хийц, үнэнхүү хосгүй гайхамшигтай, юугаар ч орлуулшгүй бүтээл гэдгийг нотлон тогтоосон байх шаардлагатай.

Түүх, соёлын энэ баялаг өвийг нягтлан судалж, сурталчлах түүхийн үйл явцыг баримтаар нотлоход тулгуурлан олон түмнийг мэдээллээр хангах хариуцлагатай үүрэг бидний өмнө ноогдож байна.

Монголын түүхэнд холбогдох баримтат өв олон тоогоор хадгалагдаж байгаагийн дээр түүнийг судлах, шинээр олж тогтоох, эрдэм шинжилгээний эргэлтэд оруулж, улсын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан үүсгэх ажил чухал шаардлагатай болж байна. Гэхдээ олон улсын хэмжээнд хил дамнасан соёлын өвийг бүртгүүлэхэд баримтлах олон улсын эрх зүйн бичиг баримт байдаг. Монголчуудын түүх, соёлтой холбоотой баримтуудыг олж тогтоон тодруулахад хувь хүний цуглуулга, дотоод гадаадын номын сан, музей, архивуудын данс бүртгэлийг шүүхээс гадна Монголын тухай нэгэнт хэвлэн нийтлэгдэж олны хүртээл болгосон хувь

хүмүүсийн тэмдэглэл, судалгааны материалууд, нэн ялангуяа мэргэжлийн монгол судлалын зохиол бүтээлүүдийг нарийвчлан үзэх нь туйлын чухал. Учир нь, тэдгээрийн зохиогчид нь нэг бол тухайн цаг үед амьдарч, бодит байдлыг нүдээр үзсэн, эсвэл түүхийн эх сурвалжуудыг сайтар нягталж судалсан хүмүүс байдаг бөгөөд чухам ямар баримтыг үзэж ашигласнаа зохиол номдоо тодорхой заасан байдаг. Энэ бол дэлхийн олон оронд байгаа Монгол Улстай холбоо бүхий түүхэн баримтуудын баялаг сан хөмрөгүүдэд нэвтрэх нэг чухал түлхүүр мөн.

# **“МОНГОЛ УЛСЫН БАРИМТАТ ӨВИЙН БҮРТГЭЛ”-Д НЭР ДЭВШҮҮЛЭХ ДУРСГАЛЫГ ТАНЬЖ ТОГТООХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН АЖЛЫН ДААЛГАВАР**

## **1. Нийтлэг үндэслэл, ажлын даалгаврын зорилт**

1.1. ЮНЕСКО-оос дэлхийн түүх, хүн төрөлхтний соёл иргэншилд онцгой нөлөө үзүүлсэн, дэлхийн улс орны түүхийн дурсамж, ой санамжийг илэрхийлэх “Баримтат өв”-д хамаатах түүх, соёлын дурсгал, эд өлгийн зүйлийг тусгайлан бүртгэж, тэдгээрийг хадгалж, хамгаалах зорилгоор “Дэлхийн дурсамж” хөтөлбөрийг 1992 оноос эхлүүлжээ.

1.2. Энэхүү ажлын даалгаврын (цаашид Ажлын даалгавар гэх) зорилт нь Монгол Улсын холбогдох хууль, тогтоомж, Засгийн газрын тогтоол, мөрийн хөтөлбөр, Олон улсын гэрээний үзэл баримтлалд нийцүүлэн, “Монгол Улсын баримтат өвийн бүртгэлд”-д нэр дэвшүүлэх дурсгал, эд өлгийн зүйлийг таньж тогтоох шалгуурыг (цаашид Шалгуур гэх) тодорхойлоход оршино.

## **2. Шалгуурыг үнэлэх ажлын хэсэг**

2.1. Нэр дэвшүүлсэн дурсгал, эд өлгийн зүйл нь шалгуурыг хангах эсэхийг хянах ажлыг тусгайлан

байгуулсан ажлын хэсэг (цаашид Ажлын хэсэг гэх) гүйцэтгэнэ.

2.2. Ажлын хэсэгт төрийн болон орон нутгийн удирдах болон соёлын асуудал эрхэлсэн байгууллага, улсын болон аймаг орон нутгийн архив, музей, судалгааны байгууллага, эрдэмтэн судлаачийн төлөөлөл зайлшгүй орсон байна.

### **3. Дурсгалын хамрах хүрээ**

3.1. Төрийн болон орон нутаг, хувийн хэвшлийн музей, орон нутаг судлах танхим,

3.2. Судалгааны байгууллагын төрөлжсөн сан хөмрөг,

3.3. Үндэсний болон аймаг орон нутаг, сумын номын сан,

3.4. Үндэсний болон аймаг орон нутаг, төрөлжсөн архив

3.5. Монголын үндэсний радио, телевизийн сан хөмрөг

3.6. Сүм хийд, шашны байгууллага

3.7. Хувь хүн, эртний эдлэл цуглуулагч

3.8. Байгаль дээр орших түүх, соёлын үл хөдлөх дурсгалын зарим төрөл, зүйл.

### **4. Дурсгалын төрөл, зүйл**

4.1. Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл

4.1.1. Түүх (гар бичмэл, сонин, ном судар, мөнгөн тэмдэгт, марк ил захидал, дуу, дүрс бичлэг, гэрэл зураг, туг, тамга тэмдэг гм)

4.1.2. Археологи (зоос, төрөл бүрийн гар бичмэл зүйлс зэрэг археологийн олдвор)

4.1.3. Дүрслэх урлаг (зурсан, сийлсэн, оёмол хатгамал, баримал зэрэг төрөл бүрийн урлагийн бүтээл)

4.1.4. Шашин шүтлэг (танка зураг, ном судар, бар дардас гм)

4.1.5. Угсаатны зүй (бичээс тэмдэглэгээ бүхий ахуй хэрэглээний эд зүйлс)

## **4.2. Түүх, соёлын үл хөдлөх дурсгал**

4.2.1. Хүн чулуу (онцлог ур хийц, дүрслэл, бичээс тэмдэглэгээ бүхий хүн чулуун дурсгал),

4.2.2. Хадны зураг, тамга, бичээс (түүхэн үйл явдлын тэмдэглэсэн бичээс, байгаль, аж ахуй, амьдралыг харуулсан зураг, түүхэнд холбогдох тамга тэмдэг зурлага гм),

4.2.3. Гэрэлт хөшөө (түүхэн үйл явдлыг бичиж тэмдэглэсэн бичээс, шүлэг, яруу найраг гм).

## **5. “Монгол Улсын баримтат өвийн**

### **бүртгэл”-д нэр дэвшүүлэх шалгуур**

*(Энэхүү шалгуур Ерөнхий аргачлалын 2.9-2.12 зүйлд буй)*

5.1. Нэр дэвшиж буй дурсгал, эд өлгийн зүйл нь дэлхийн болон бүс нутагт онцгой ховор, хосгүй бөгөөд давтагдашгүй байх, хүн төрөлхтний соёл иргэншилд онц нөлөө үзүүлсэн байх шаардлагатай төдийгүй, тухайн дурсгал нь устах

аваас хүн төрөлхтний соёлын өвийн санд нөхөгдөшгүй гарз хохирол учрахыг анхаарсан байна.

5.2. Нэр дэвшиж буй дурсгал, эд өлгийн зүйл нь эх хувилбараар (оргиналь) байна.

5.3. Тухайн дурсгал, эд өлгийн зүйл нь дараах шалгуурын аль нэгийг хангасан бол баримтат өвд хамаатуулна. Үүнд:

**Шалгуур 1.** Монгол төрт ёсны түүх, холбогдох засаг захиргаа, түүхэнд холбогдох үйл явдлыг тэмдэглэсэн, гэрчилсэн байх;

**Шалгуур 2.** Амьдрах ёс, соёл, шинжлэх ухааны үнэ цэнтэй бүтээл байх;

**Шалгуур 3.** Түүхэн үйл явдал, газар нутаг, уул усны түүхэн нэр дурдагдсан, байгаль, барилга байшин зэргийг тэмдэглэсэн, дүрсэлсэн байх;

**Шалгуур 4.** Олон улсын болон бүс нутаг, Монгол Улс, аймаг орон нутгийн алдар цуутай түүхэн хүнтэй холбогдсон байх.

5.4. Нэр дэвшүүлэх шалгуурын 5.2-д дурдсан шаардлага хангасан ч эх хувилбар биш (оргиналь) бол шалгуурыг хангасан гэж үзэхгүй.

## **6. Шалгуурыг тодорхойлоход шаардагдах үзүүлэлт, мэдээлэл**

6.1. Нэр дэвшүүлж буй дурсгал, эд өлгийн зүйлийн бүрэн бүтэн байдал, мөн чанар, өвөрмөц байдал, утга санаа, түүхийн үнэн зөв байдлыг

шинжлэх ухааны үндэслэлтэй мэдээлэл, судалгаа шинжилгээнд үндэслэн нотлох ба гэрэл зураг, дүрс бичлэгээр баталгаажуулна. Үүнд:

**1 дүгээр шалгуурын хүрээнд:** Тухайн дурсгал, эд өлгийн зүйл нь Монголын төр, засаг захиргааны нэгжийн таних тэмдэг болсон бүх цаг үеийн тамга, тэмдэг, туг, зарлиг зэрэг болон түүхийн онцгой үйл явдлыг бичин тэмдэглэсэн түүхийн ном судар, бичээс, гэрэл зураг, дуу, дүрс бичлэг зэргийг хамаатуулан ойлгож болно.

**2 дугаар шалгуурын хүрээнд:** Монгол үндэстэн, угсаатны амьдрах өвөрмөц соёл, байгаль эх дэлхий, ертөнцийг таньж мэдэх арга ухааныг тэмдэглэсэн, дүрсэлсэн дурсгалын төрөл зүйл, эд өлгийн зүйлийг хамаатуулан ойлгож болно.

**3 дугаар шалгуурын хүрээнд:** Монгол Улс, аймаг орон нутгийн байгалийн болон түүхэн газар нутаг, уул, овоо, гол мөрөн, тухайн бүс нутагт болсон түүхэн үйл явдал, барилга архитектурын дурсгал зэргийг тэмдэглэсэн, дүрсэлсэн дурсгалын төрөл зүйл, эд өлгийн зүйлийг хамаатуулан ойлгож болно.

**4 дүгээр шалгуурын хүрээнд:** Олон улсад болон Монгол Улсад нэр хүнд, алдар цуутай түүхэн хүний улс төр, соёл, шинжлэх ухаанд хувь нэмэр оруулсан түүхэн үйл явдлыг илэрхийлэх эх гар бичмэл, амьдрал ахуйг харуулсан гэрэл зураг,

дүрс бичлэг болон тэмдэглэсэн, дүрсэлсэн дурсгалын төрөл зүйл, эд өлгийн зүйлийг хамаатуулан ойлгож болно.

## **7.“Монгол Улсын баримтат өвийн бүртгэл”-ийн ангилал**

7.1. “Монгол Улсын баримтат өвийн бүртгэл”-ийн ангиллыг тухай нэр дэвшиж буй дурсгалын “түүхэн тодорхой орон зай, цаг үеийн аль нэг хэсгийг төлөөлж чадах байгаль, нийгэм, түүх, соёл, урлаг, шинжлэх ухааны үнэ цэн холбогдол”-ыг харгалзан үзэж дараах ангилалд зэрэглэнэ.

Үүнд:

7.1.1. Баримтат өвийн урьдчилсан жагсаалт.

7.1.2. Аймаг, нийслэлийн жагсаалт.

7.1.3. Үндэсний жагсаалт.

7.1.4. Бүс нутгийн жагсаалт,

7.1.5. Олон улсын жагсаалт.



## БАРИМТАТ ӨВИЙН ЖАГСААЛТ

Иргэн, соёлын өвийг эзэмшигч байгууллагуудаас СӨҮТ-ийн УНБМСанд хүлээн авсан Монгол Улсын баримтат өвийн жагсаалтыг Дэлхийн дурсамж хөтөлбөрийн монголын үндэсний хороо хэлэлцэж баталсан баримтат өвүүдийг Үндэсний баримтат өв хэмээн үзэж Монгол Улсын үндэсний баримтат өвийн жагсаалт үйлдэж олон нийтэд танилцуулна. Ийнхүү Үндэсний баримтат өвийн жагсаалттай болсноор цаашид Дэлхийн дурсамж хөтөлбөрийн Ази-Номхон далайн бүс нутгийн өв, Дэлхийн өвийн бүртгэлд нэр дэвшүүлэх өвийг сонгох боломжтой.

Энэ утгаараа Монгол Улсын үндэсний баримтат өвийн жагсаалтад иргэн, соёлын өвийг эзэмшигч байгууллагуудад хадгалж байгаа баримтат өв нь хэний, ямар байгууллагын баримтат өв болохоос үл хамааран түүх, соёл, шинжлэх ухаан, танин мэдэхүйн чухал ач холбогдолтой болох нь нийт улс үндэстний болон бүс нутаг болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх боломж нээгдэх учиртай.

## Баримтат өвийн жагсаалтын төрөл



Зураг 6

### Эхний шатанд

Баримтат өвийн бүртгэлд нэр дэвшүүлэх өвийн урьдчилсан жагсаалт Соёлын өвийг эзэмшигч байгууллага, сумын орон нутаг судлах танхим, сүм хийд, хувь хүнд хадгалагдаж байгаа баримтат өвийг бүртгэж жагсаалт үйлдэж, УНБМСанд хүргүүлнэ. Энэхүү урьдчилсан жагсаалтад дээрх баримтат өв бүртгэх маягт шалгуурын дагуу сум, аймаг, үндэсний хэмжээнд

ач холбогдол бүхий баримтат өвүүдийг аргачлалын дагуу үнэн зөв хийсэн байх шаардлагатай. Баримтат өвийн урьдчилсан жагсаалт нь тухайн баримтат өвийн хайлтын системийг боловсронгуй болгож, хүртээмж, ашиглалтыг сайжруулж баримтат өвийн агуулга ач холбогдол, эзэмшигч, өмчлөгч, байршлын мэдээлэл лавлагааны нэгдсэн бүртгэл мэдээллийн сан үүсгэж сум аймгаг, үндэсний хэмжээнд ач холбогдол бүхий баримтат өвийн жагсаалт гаргаж Монгол Улсын үндэсний жагсаалт, Дэлхийн дурсамж хөтөлбөрийн Ази Номхон далайн бүс нутгийн жагсаалт дэлхийн өвийн жагсаалтыг өргөтгөх зорилготой. Иймээс урьдчилсан жагсаалтын ач холбогдол маш их юм.

### Дараагийн шатанд

УНБМСан урьдчилсан жагсаалтыг хүлээн авснаар бүртгэл судалгааны тайлан гаргаж Дэлхийн дурсамж хөтөлбөрийн Монголын үндэсний хороонд хүргүүлснээр сум, аймаг, үндэсний баримтат өвийн жагсаалтад орж болох баримтат өвүүдийг тусгай шинжээчдийн дүгнэлтээр тодруулж баталгаажуулснаар Үндэсний баримтат өвийн жагсаалтад орох өв тодорхой болох юм. Үндэсний баримтат өвийн жагсаалт батлагдсанаар цаашид Ази-Номхон

далайн бүс нутгийн өв, Дэлхийн өвд Монгол Улсаас баримтат өвийг бүртгүүлэх ажил явагдана. Эдгээр жагсаалтад иргэн, аж ахуйн нэгж, сум аймаг, улсын эзэмшил, өмчлөлд байгаа ямар ч төрлийн өв дээрх шалгуурыг хангасан бол нэр дэвшүүлэх нь нээлттэй байна.

## **МОНГОЛ УЛСААС АЗИ-НОМХОН ДАЛАЙН БҮС НУТГИЙН БОЛОН ДЭЛХИЙН ӨВД БҮРТГҮҮЛСЭН ӨВИЙН ЖАГСААЛТ**

Монгол Улсаас Ази-Номхон далайн бүс нутгийн өвийн жагсаалтад дараах өвүүдийг бүртгүүлээд байна. Үүнд: Монгол Улсаас ЮНЕСКО-ийн “дэлхийн дурсамж” хөтөлбөрийн Ази-номхон далайн бүс нутгийн болон Дэлхийн өвд бүртгүүлсэн дараах өвүүдийн тодорхойлолтыг энд оруулахдаа “Музейн сан хөмрөгийг бүртгэх, баримтжуулах заавар”-ын дагуу бичлээ.



**Нэр:** Лу Алтан товч

**Бүтээгч, зохиогч:** Лувсанданзан

**Холбогдох он цаг:** 1651

**Хадгалагдаж байгаа газар:** Монгол Улсын  
Үндэсний номын сан

**Дурсгалын шинж байдал:** Муутуу цаасан дээр  
30 мөрөөр монгол бичгээр бичсэн гар бичмэл.

**Материал:** Муутуу цаас, хар бэх

**Хэмжээ:** өргөн 18.8 см, урт 62.0 см

**Хувийн дугаар:** 24/63

2009 онд ЮНЕСКО-ийн Дэлхийн дурсамж  
хөтөлбөрийн Ази-Номхон далайн бүс нутгийн өвд  
бүртгэсэн.



**Нэр:** “Мэргэд гарахын орон нэрт толь бичгийн модон бар”

**Бүтээгч:** Хамтын бүтээл /Агийн дацан/

**Холбогдох он цаг:** 1924

**Хадгалагдаж байгаа газар:** Монгол Улсын Үндэсний номын сан

**Дурсгалын шинж байдал:** Хуш модон дээр 4 мөрөөр төвөд, монгол үсгээр ухаж сийлсэн, 11 аймаг болгон хуваасан, аймаг бүрийн эхний хоёр нүүрийн бичвэрийн хажууд бурхдын хөрөг дүрс бүхий сийлбэртэй 378 ширхэг модон бар.


**Материал:** Хуш мод

**Хэмжээ:** урт 54.7 см, өргөн 7.4 см

**Хувийн дугаар:** 24/96-1 24/96-7

**Товч тодорхойлолт:** Жанжаа хутагт Ролбийдоржийн удирдан зохиосон Төвд-Монгол хэлний толь бичгийн модон бар. Монгол Улс Ази тивд тусгаар тогтнолоо зарлан тунхагласан түүхэн цаг үетэй давхцаж, монголын орчин цагийн хэвлэх үйлдвэр булаа эргүүлж анхны хэвлэмэл хуудсаа гаргаж байсан тэр үед “Мэргэд гарахын орон” нэрт Төвд-Монгол толь бичгийн модон барыг Монгол Улсын Судар бичгийн хүрээлэнгийн санаачилгаар 1924 онд Буриадын Агын дацанд бүтээлгэжээ. Энэхүү модон бар нь монголчуудын төдийгүй Ази дорно дахины орнуудын ном хэвлэлийн түүхэн уламжлалын гэрч болж,

Монголын нийгэм соёлын хөгжил дэвшил, өөрчлөлт шинэчлэлийн үйл явцын ой санамж дурсамжийг тээн хадгалж ирсэн үндэсний баримтат өв мөн. Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 105 дугаар тогтоолоор түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалтад, 2011 онд ЮНЕСКО-ийн “Дэлхийн Дурсамж” хөтөлбөрийн Ази Номхон далайн бүс нутгийн өвийн жагсаалтад тус тус бүртгэсэн.



**Нэр:** Сахиусан дара эх

**Бүтээгч, зохиогч:** С.Шагж

**Холбогдох он цаг:** 1914

**Хадгалагдаж байгаа газар:** Монгол Улсын  
Үндэсний номын сан

**Дурсгалын шинж байдал:** Цагаан, ногоон дарь эхийн магтаалыг хар, улаан бэхээр бичсэн. 62

бадаг шүлэг, 250 мөр, 5718 үсэг тэмдэгт, 2510 цэг шад, бүхэлдээ 8228 тэмдэгтийг багтаасан.

**Материал:** Орос цаас, хар, улаан бэх

**Хэмжээ:** өргөн 4,9 см, урт 5,4 см

**Хувийн дугаар:** 24/56

**Товч тодорхойлолт:** Энэхүү бүтээлийг ХХ зууны эхэнд гэвш С.Шагж (1886-1938) өчүүхэн цаасанд шахаж бичсэн байна. С.Шагж гэвшийн тус бүтээлийг эрдэмтэн зохиолч Ц.Дамдинсүрэн олон жил хадгалж байгаад Улсын номын санд ховор хуучин ном судрын тусгай үзэсгэлэнгийн танхим байгуулахад буюу 1980 оны 10 сарын 24-нд бэлэглэжээ. Төвөдийн сав үсгээр 79 мөрөөр маш өчүүхэн зайд улаан шунх, хар бэхийг алаглуулан үлэмж чигжүү бичсэн бөгөөд төвд хэлний 62 шүлэг буюу бадаг, 250 шад буюу мөр, 5718 үсгийн тэмдэгт, 2510 цэг шадыг багтаажээ. Монгол Улсын Засгийн газрын 2002 оны 118 дугаар тогтоолоор түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалтад, 2014 онд ЮНЕСКО-ийн Дэлхийн дурсамж хөтөлбөрийн Ази номхон далайн бүс нутгийн баримтат өвд тус тус бүртгэсэн.

дараах өвүүдийг ЮНЕСКО-ийн Дэлхийн дурсамж хөтөлбөрийн Дэлхийн өвийн жагсаалтад бүртгүүлсэн өвүүд.





**Нэр:** Лу Алтан товч

**Бүтээгч, зохиогч:** Лувсанданзан

**Холбогдох он цаг:** 1651

**Хадгалагдаж байгаа газар:** Монгол Улсын  
Үндэсний номын сан

**Дурсгалын шинж байдал:** Муутуу цаасан дээр  
30 мөрөөр монгол бичгээр бичсэн гар бичмэл.

**Материал:** Муутуу цаас, хар бэх

**Хэмжээ:** өргөн 18.8 см, урт 62.0 см

**Хувийн дугаар:** 24/63

**Товч тодорхойлолт:** XVII зууны бичгийн хүн гүүш Лувсанданзан шавь нарын хамт туурвисан учир судлаачдын дунд “Лу Алтан товч” хэмээн алдаршсан. “Лу Алтан товч”-д “Монголын нууц товчоо”-ны 282 зүйлийн 233 зүйл нь бараг тэр хэвээр агуулагдсан учир “Монголын нууц товчоо”-ны монгол үсгээр үлдсэн нэгэн эх гэж үздэг. Тус сурвалжид Чингис хаанаас Лигдэн хутагт хаан хүртэлх үеийн Монголын төрийн түүхийн чухал мэдээ баримтыг агуулжээ. Энэ сурвалж Хан

Хэнтий уулын аймгийн Баянтүмэн хошууны  
Еншөөбү отгийн Дамдин тайж хэмээх хүнд  
хадгалагдаж байсныг Судар бичгийн  
хүрээлэнгийн анхны дарга О.Жамьян гүн 1926 онд  
олж авчирчээ. 1995 онд Монгол Улсын Засгийн  
газрын 241 тогтоолоор түүх, соёлын хосгүй үнэт  
дурсгалт зүйлийн жагсаалтад, 2011 онуудад  
ЮНЕСКО-ийн Дэлхийн дурсамж хөтөлбөрийн  
дэлхийн өвд бүртгэсэн.



**Нэр:** Монгол шунхан Данжуур

**Бүтээгч, зохиогч:** Хамтын бүтээл

**Холбогдох он цаг:** 1749 он

**Хадгалагдаж байгаа газар:** Монгол Улсын  
Үндэсний номын сан

**Материал:** Муутуу цаас, улаан бэх

**Хэмжээ:** өргөн 22.7 см, урт 71.8 см

## Хувийн дугаар: 24/25

**Товч тодорхойлолт:** Монголчууд буддын шашин дэлгэрч эхэлсэн тэр цагаас эхлэн Данжуурыг орчуулж эхэлсэн бөгөөд XVIII зууны тэргүүн хагаст Жанжаа хутагт Ролбийдорж, Ширээт хутагт Лувсандамбийням тэргүүтэй 200 орчим гүүш нар төвд хэлнээс монгол хэлнээ орчуулан 1742-1749 онд Бээжинд модон бараар барлан 226 ботиор хэвлэсэн. Халхын Сайн ноён хан аймгийн засаг хошой чин ван Наянтын харьяа Цахарын сүрэг хошууны Шашныг бадруулагч сүмд тахиж байсан нэгэн иж Данжуур судрыг Судар бичгийн хүрээлэнгийн дарга О.Жамьян гүн 1924 онд Наянт чин вантай тус хүрээлэнгийн номын санд үүрд хадгалуулах гэрээ байгуулж, 1923 онд залж авчирчээ. Монгол Улсын Засгийн газрын 1993 оны 241 дүгээр тогтоолоор түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалтад, 2011 онд



ЮНЕСКО-ийн Дэлхийн дурсамж хөтөлбөрийн дэлхийн өвд тус тус бүртгэсэн.

**Нэр:** Данжуурын гэрэлт хөшөө

**Бүтээгч:** Дэндэв (1891-1960)

**Холбогдох он цаг:** 1928-1955

**Хадгалагдаж байгаа газар:** Монгол Улсын  
Үндэсний номын сан

**Дурсгалын шинж байдал:** Энэхүү гэрэлт хөшөө хоёр луу дүрсэлсэн титэм хэсэг, есөн зүйл бүхий гэрээ бичиг сийлсэн гол хэсэг, бадам цэцэг бүхий суурь хэсэг гэсэн 3 хэсгээс бүтсэн. Гол хэсгийн нүүрэн талд монгол бичээр 13 мөрөөр, арын хэсэгт 6 мөрөөр гэрээ бичгийг сийлж хүрээлсэн.

**Материал:** Боржин чулуу

**Хэмжээ:** өндөр 248.0 см, өргөн 38.0 см

**Хувийн дугаар:** 29/1

**Товч тодорхойлолт:** Судар бичгийн хүрээлэнгийн дарга О.Жамьян уг ажлыг бичээч Н.Дэндэвт даалгаж, Дамбадаржаа хийдийн бичээст хөшөөний маягийг дуурайлган загвар гаргаж батлуулан, тус гэрэлт хөшөөг боржин чулуун дээр 1929 онд сийлж эхлээд цөөн хэдэн үгийг төгсгөж чадалгүй орхижээ. Хожим Шинжлэх ухааны хүрээлэнгийн даалгавраар 1955 онд Н.Дэндэв 64 настай байхдаа сүүлийн 64 үсгийг гүйцээн сийлж дуусгаад нэрээ тавьсан байна. Тэрээр 37 насандаа энэ хөшөөг хийж эхлэн, 27 жилийн дотор бүтээсэн түүхтэй. Монгол шунхан барын Данжуурыг Судар бичгийн хүрээлэнд үүрд хадгалуулах гэрээ бичиг. 1921 онд байгуулагдсан Судар бичгийн хүрээлэнгээс хуучин ном, судрыг

сурвалжлан цуглуулах ажлын хүрээнд дарга О.Жамьян, гишүүн Жонон ван Ширнэндамдин нар Бээжин хотод очиж, Халхын Сайн ноён хан аймгийн нэгэн засаг асан Наянттай уулзан, түүний харьяа Цахарын Сүрэг хошууны Шашныг бадруулагч сүмд хадгалан тахиж байсан Монгол шунхан барын Данжуурыг Судар бичгийн хүрээлэнд үүрд хадгалах тухай 9 зүйл гэрээ бичгийг Монгол улсын 14 дүгээр оны 12 сарын 28-нд (1925 он) монгол, хятад хэлээр дөрвөн хувь үйлдэн Сэцэн чин ван Наянтад нэгэн хувь, Жонон ван Ширнэндамдинд нэгэн хувь, Сэцэн чин вангийн хошуунд нэгэн хувь, Ардыг Гэгээрүүлэх яамны Судар бичгийн хүрээлэнд нэгэн хувь тус тус хадгалуулахаар болжээ. 2017 онд ЮНЕСКО-ийн Дэлхийн дурсамж хөтөлбөрийн дэлхийн өвийн дагалдах өвд бүртгэсэн.



**Нэр:** Есөн эрдэнийн ганжуур

**Бүтээгч, зохиогч:** Хамтын бүтээл

**Холбогдох он цаг:** 1819 он

**Хадгалагдаж байгаа газар:** Монгол Улсын  
Үндэсний номын сан

**Материал:** Болгомол хар цаас, есөн эрдэнэ, мод  
торго

**Хэмжээ:** өргөн 16.5 см, урт 70.5 см

**Хувийн дугаар:** 24/4-1-110

**Товч тодорхойлолт:** Бурхан багшийн зарлиг сургаалуудыг эмхэтгэн төвөд хэлнээ орчуулсан нь Ганжуур буюу Зарлигийн хураангуй хэмээх хөлгөн судар болно. Есөн эрдэнийн Ганжуурыг иж бүрнээр нь болгомол хар цаасан дээр есөн эрдэнээр урлажээ. Энэхүү Есөн эрдэнийн Ганжуурыг Их хүрээний Дашчоймпэл дацанд залж

байсныг 1937-1938 онд Шинжлэх ухааны хүрээлэнгийн номын санд шилжүүлжээ. Энэ бүтээл нь тухайн үеийн олон арван алдартай бичгийн мэргэд, урчууд өөрсдийн гараар бурхан шүтээн, тахилын зураг, уран тансаг хээ угалз сэлтийг нь бүтээсэн цорын ганц хосгүй бүтээл юм. Монгол Улсын Засгийн газрын 2002 оны 118 дугаар тогтоолоор түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалтад, 2013 онд ЮНЕСКО-ийн Дэлхийн дурсамж хөтөлбөрийн дэлхийн өвд тус тус бүртгэсэн.

## **Баримтат өвийн хүртээмж**

Баримтат өвийг шинжлэх ухааны эргэлтэд оруулж дотоод гадаадын судлаачдад нээлттэй байлгаж, монголчуудыг эх түүхээ сайтар мэддэг, уламжлал соёлоо хайрлан хүндэтгэдэг үзэл хүмүүжлээр хүмүүжүүлэх, хүртээмжийг сайжруулахад нийт соёлын байгууллагын ажилтны үүрэг асар их билээ.

Монгол улсад хадгалагдаж буй баримтат өвийн бүртгэл судалгааны ерөнхий түвшнийг тогтоосноор Улсын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан бий болж монгол судлалаар ажилладаг нийт судлаач эрдэмтэд, түүх сонирхогчдын судалгааны үр дүн сайжирна. Монголын түүхэнд холбогдох шинэ баримтат өвийн талаар харилцан мэдээлэл солилцох боломж бүрдэнэ.

Монголын түүхэнд холбогдох баримтат өвийг шинээр нээн илрүүлэх, энэ ажилд нийт судлаачдын анхаарлыг төвлөрүүлнэ. Хамтарсан ном зохиол, баримтат өвийн эмхэтгэл, катологи хэвлэн гаргах боломж нөхцөл, сурталчилгааны ажил сайжирна. Үр дүнг бүх нийтээр хүртэх болно. Дэлхийн дурсамж хөтөлбөрийн Монголын Үндэсний Хорооны үйл ажиллагааны тогтолцоог схемчлэн харуулбал:






Монгол Улсын баримтат өвийн талаарх үйл  
ажиллагаанд оролцогч талууд

- 1 •Соёлын яам, ГХЯ, ЮНЕСКО-ийн МҮК
- 2 •Дэлхийн дурсамж хөтөлбөрийн МҮХ
- 3 •Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг СУГ
- 4 •Улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн сан СӨҮТ  
• (ҮНС, Музеи, Архив, Судалгааны байгууллагууд)
- 5 •Аймгийн БМС-аймгийн музеин БМС
- 6 •Сум, дүүргийн БМС
- 7 •Аж ахуйн нэгж байгууллага
- 8 •Иргэн

Баримтат өвийн үндэсний бүртгэл тогтолцооны  
схем



“Монгол Улсын баримтат өв”-д тухайн өвийг нэр дэвшүүлэхдээ бүртгэхдээ тухайн дурсгалын нийтлэг шинж чанараас хамаарч

дараах 16 төрөл зүйлээр Улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санд бүртгэж байна.

## **ХАВСРАЛТ**

Баримтат өвд хамаарах удирдлагын баримт бичгүүд

- ЮНЕСКО-гийн “Дэлхийн өвийн конвенци” 1972
- "Соёлын эд зүйлсийг хууль бусаар импортлох, экспортлох, өмчлөх эрхийг шилжүүлэхээс сэргийлэх тухай" ЮНЕСКО-гийн конвенци 1970
- Үндсэн хууль 1992.01.13
- Соёлын тухай хууль 1996.04.11
- Архивын тухай хууль 1998.01.02
- Соёлын өвийг хамгаалах тухай хууль 2014 он
- Эрдэнэсийн сангийн тухай хууль 2002.12.06
- Төрөөс баримтлах соёлын бодлого 1996.04.08
- Морин хуураа дээдлэн дэлгэрүүлэх тухай 2002.02.11-ний 17 дугаар зарлиг
- Монгол хөөмийн урлагийг хөгжүүлэх тухай 2004.01.05-ны 01 дугаар зарлиг
- Монголын Нууц Товчоог мөнхөд эрхэмлэн дээдлэх тухай 2004.02.18-ны 23 дугаар зарлиг

- Уртын дуугаа өвлөн дэлгэрүүлэх тухай 2004.09.01-ний 134 дугаар зарлиг
- Монгол төрийн үндэсний хөгжмийн их найрал байгуулах тухай 2005.02.16-ны 20 дугаар зарлиг
- Гар урлал болон урлагийн зориулалттай зүйлс, музейн үйл ажиллагаанд тавих шаардлага, MNS 5634: 2006
- Номын сангийн орчин нөхцөл, үйл ажиллагаанд тавих шаардлага, MNS 5742:2007
- Архив, номын сангийн өв санг хадгалж, хамгаалахад тавигдах шаардлага, MNS 150 11799:2007
- Түүх, соёлын дурсгалт зүйлийн тооллого явуулах журам Засгийн газрын 1994.12.28-ны 233 дугаар тогтоолын 1-р хавсралт
- Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын хяналтын дүрэм Засгийн газрын 1999.10.13-ны 164 дүгээр тогтоол
- Засгийн газрын 1995.12.23-ны 241 дүгээр тогтоолоор баталсан “Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалт”-д нэмэлт оруулах тухай Засгийн газрын 1999.07.07-ны 110 дугаар тогтоол

- Засгийн газрын 1995.12.23-ны 241 дүгээр тогтоолоор баталсан “Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалт”-д нэмэлт оруулах тухай Засгийн газрын 2000.11.15-ны 175 дугаар тогтоол
- Засгийн газрын 1995.12.23-ны 241 дүгээр тогтоолоор баталсан “Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалт”-д нэмэлт оруулах тухай Засгийн газрын 2002.06.10-ны 118 дугаар тогтоол
- Түүх, соёлын дурсгалт зүйлийг хувилан олшруулах, загвараар нь бэлэг дурсгалын зүйл бэлтгэх, кино, дүрс бичлэг, гэрэл зураг авах, марк, ил захидал, цомог хийх журам Засгийн газрын 2003.01,30-ны 23 дугаар тогтоол
- Түүх, соёлын дурсгалт зүйлийг зөөж тээвэрлэх журам Засгийн газрын 2003.01.30-ны 23 дугаар тогтоол
- Засгийн газрын 1995.12.23-ны 241 дүгээр тогтоолоор баталсан “Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалт”-д нэмэлт оруулах тухай Засгийн газрын 2003.05.21-ний 124 дүгээр тогтоол
- Засгийн газрын 1995.12.23-ны 241 дүгээр тогтоолоор баталсан “Түүх, соёлын хосгүй

үнэт дурсгалт зүйлийн жагсаалт”-д нэмэлт оруулах тухай Засгийн газрын 2004.05.05-ны 108 дугаар тогтоол

- Засгийн газрын 1995.12.23-ны 241 дүгээр тогтоолоор баталсан “Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалт”-д нэмэлт оруулах тухай Засгийн газрын 2005.05.31-ний 116 дугаар тогтоол
- Засгийн газрын 1995.12.23-ны 241 дүгээр тогтоолоор баталсан “Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалт”-д нэмэлт оруулах тухай Засгийн газрын 2006.6.28-ны 144 дугаар тогтоол
- Засгийн газрын 1995.12.23-ны 241 дүгээр тогтоолоор баталсан “Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалт”-д нэмэлт оруулах тухай Засгийн газрын 2008.03.19-ний 103 дугаар тогтоол
- Монголын Үндэсний түүхийн музейг өөрчлөх тухай Засгийн газрын 2008.04.09-ний 129 дүгээр тогтоол
- Соёлын өвийн төвийг өргөжүүлэх тухай Засгийн газрын 2008.07.29-ний 302 дугаар тогтоол
- Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийг хамгаалах, сэргээн засварлах үндэсний

хөтөлбөр Засгийн газрын 1998.04.08-ны 51 дүгээр тогтоол 1999-2005 он

- Үндэсний соёлын өвийн мэдээллийг тоон системд оруулан хадгалах хөтөлбөр Засгийн газрын 2005.12.07-ны 244 дүгээр тогтоол 2006-2008 он
- Түүх, соёлын дурсгалт зүйлийг сурвалжлан олох, судалгаа шинжилгээ хийх журам Соёлын сайд, Шинжлэх ухаан, Боловсролын сайдын 1995.01.13-ны 11/10 дугаар хамтарсан тушаал
- Утга соёлын өвийг сурвалжлан олох, судалж шинжлэх журам БСШУЯ-ны сайдын 2003.11.11-ны 375 дугаар тушаал
- Түүх, соёлын дурсгалт зүйлийн зэрэглэл, үнэлгээг тодорхойлох мэргэжлийн зөвлөлийн ажиллах журам БСШУЯ-ны сайдын 2005.08.31-ны 262 дугаар тушаал /БСШУЯ-ны сайдын 2007.01.10-ны 01 тоот тушаалаар 2005 оны 262 дугаар тушаалын 1 дэх заалтыг өөрчилсөн/
- “Үндэсний соёлын өвийн мэдээллийг тоон системд оруулан хадгалах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх тухай Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 03.05-ны 55-р тушаал



- Соёлын өвийн улсын бүртгэл-мэдээллийн санг бүрдүүлэх, уг санд бүртгэх журам БСШУЯ-ны сайдын 2009.03.09-ны 78 дугаар тушаал
- Архивын байгууллагад дагаж мөрдөх галын аюулгүйн дүрэм ХЗДХЯ-ны сайдын 2001.04.27-ны 122 тушаал
- Соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхүүлэн дэмжих тухай конвенци. 2005
- "Зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлийг хамгаалах тухай" 1954 оны Гаагийн хэлэлцээр
- БНМАУ-ын музейнүүдийн сан хөмрөгийн тоо бүртгэл эрдэм шинжилгээний тодорхойлолтын заавар. Соёлын яамны сайдын 1990 оны 335 дугаар тушаал
- Улс, аймгийн музейд үзмэр худалдан авах журам Гэгээрлийн сайдын 1999.10.20-ны 223 дүгээр тушаал
- Монгол Улсын музейн сан хөмрөгийн дүрэм БСШУЯ-ны сайдын 2005.11.08-ны 347 дугаар тушаал
- Монголын үндэсний музейн дүрэм БСШУЯ-ны сайдын 2008.05.02-ны 230 дугаар тушаал

- Улс, орон нутгийн музейн дүрэм БСШУЯ-ны сайдын 2009.03.23-ны 38 дугаар тушаал
- Музейн үзмэрийг хадгалж хамгаалах заавар БСШУЯ-ны сайдын 2009.03.23-ны 98 дугаар тушаал
- Нэгдсэн Үндэстний Боловсрол, Шинжлэх Ухаан, Соёлын Байгууллагын Дүрэм 1945.11.16
- Хөшөө дурсгал, дурсгалт газрыг хадгалж хамгаалах, сэргээн засварлах тухай олон улсын харти. 1964 он.
- Соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхиүлэн дэмжих тухай Конвенц 2005.10.20

## ТОВЧИЛСОН ҮГ

ЮНЕСКО-Нэгдсэн Үндэстний Байгууллагын  
боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага  
БСШУЯ-Боловсрол Соёл Шинжлэх Ухааны Яам  
ДДХМҮХ- Дэлхийн дурсамж хөтөлбөрийн Монголын  
Үндэсний Хороо

ДДХ-Дэлхийн дурсамж хөтөлбөр

СӨҮТ- Соёлын өвийн үндэсний төв

ҮБӨ-Үндэсний баримтат өв

МҮК-Монголын Үндэсний комисс

НҮБ-Нэгдсэн Үндэстний Байгууллага

УБМНС-Улсын бүртгэл, мэдээлэлийн нэгдсэн сан

СБХ-Судар бичгийн хүрээлэн

Г.М-Гэх мэт

МУ-Монгол Улс

ҮТА-Үндэсний төв архив

CD-Compact Disc

DVD-Digital Video Disc

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Соёлын өвийг хамгаалах тухай хууль  
<https://legalinfo.mn/mn/detail/10439>
2. Биет бус соёлын өв: ЮНЕСКО-ийн конвенц, удирдамж, зөвлөмж. УБ. 2009 он
3. “Монгол Улсын баримтат өвийн бүртгэлд нэр дэвшүүлэх дурсгалыг бүртгэх зөвлөмж” Соёлын яам. Баримтат өвийг бүртгэх аргачлал- сургалтад СӨҮТ- ийн захирал доктор (Ph.D) Г.Энхбатын тавьсан илтгэл
4. Судар бичгийн алтан сан УБ., 2016 он хоёр дахь хэвлэл